

“Нийтийн, насан туршийн, нээлттэй
боловсрол”/MOOC/ төсөл шалгаруулах
хөтөлбөр 2015

2015.11.30-12.09

ШУТИС

Е-Нээлттэй Институт

MOOC төсөл шалгаруулах тэтгэлэгт хөтөлбөр 2015

Зорилго

MOOC төсөл шалгаруулах тэтгэлэгт хөтөлбөрийн зорилго нь сургалтын агуулгын онлайн нээлттэй эхийг бэлдэх, е-хичээлийг хөгжүүлэх, нээлттэй мэдлэгийн нөөц материал, арга барил, технологийг боловсролд нэвтрүүлэх, Монголын нийт профессор багш, эрдэмтэн судлаачид нээлттэй нөөц, технологийг идэвхтэй ашиглах, өөрсдийн е-хичээл, нээлттэй нөөц, арга барил технологийг бүтээж, хөгжүүлэх, сургалтанд өргөнөөр нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, заах арга зүйн инновацийг урамшуулах, нийтийн нээлттэй насан туршийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн агуулга

Е-Нээлттэй Институт нь 2015-2016 оны хичээлийн жилийн хаврын улиралд их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн хичээлүүд, ерөнхий боловсролын болон насан туршийн боловсролын хичээлүүдийг нээлттэй нөөц материал, арга барил, технологийн боломжуудыг ашиглан профессор, багш нар өөрсдийн е-хичээлийг бэлдэх, хөгжүүлэх, оюутан болон насан туршийн суралцагчдад нээлттэй дэлгэн харуулах, зааж чиглүүлэх, нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгоход хамтран ажиллана.

Е-Хичээл сонгон шалгаруулалт

Е-Хичээлийн дараах 3 төрөлд төслийн саналыг сонгон шалгаруулна. Е-Нээлттэй Институт нь програм хангамж, аудио, видео бичлэг хийх зэрэг техникийн бүхий л тал дээр баг болон хамтран ажиллана.

1. Академик е-хичээл.

Их дээд сургуулиудын бүх түвшний сургалтанд заадаг, кредит тооцдог, багшийн ачаалалд ордог сургалтын хөтөлбөрийн хичээлүүдийг е-хичээл болгох 3 төслийн

саналыг шалгаруулж, хамтран хөгжүүлж, тэтгэлэг олгоно. Их дээд сургуулийн профессор, багш нар төслийн саналаа явуулах боломжтой.

2. e-Хичээлийг шинэчлэн сайжруулах

ШУТИС-ийн магистрын болон бакалаврын түвшний онлайн сургалтын e-хичээлүүдийг агуулгын болон дизайны шинэчлэн сайжруулахад зориулсан 3 төслийн саналыг шалгаруулж, хамтран ажиллаж, тэтгэлэг олгоно. Урьд нь e-хичээл хийсэн, ректорын тушаалаар e-хичээл нь онлайн сургалтанд заагдаж байгаа ШУТИС-ийн профессор, багш нар төслийн саналаа явуулах боломжтой.

3. Насан туршийн боловсролын онлайн хичээл

Их, дээд сургуулийн түвшний хичээлээс гадна ерөнхий боловсролын түвшний хичээл, насан туршийн бүхий л суралцагчдад зориулсан хичээлийг онлайн хэлбэрт хөгжүүлэхэд 3 төслийн саналыг шалгаруулж, хамтран ажиллаж, тэтгэлэг олгоно. Багшлах заах арга туршлагатай, өөрийн сургах арга барилд технологийн боломжуудыг ашиглан e-хичээлээ хөгжүүлэх сонирхолтой, Монголын нийт насан туршийн боловсрол эзэмшигчдэд онлайн хичээлээ түгээн дэлгэрүүлэх хүсэлтэй хамтран ажиллах хүн бүр энэхүү хөтөлбөрт оролцох эрхтэй.

Тэтгэлэг

- Академик e-хичээлийн 3 төслийн саналыг сонгон шалгаруулна. Тэтгэлэгийн хэмжээ тус бүр 1,500,000 төгрөг.
- E-Хичээлийн шинэчлэн сайжруулах 3 төслийн саналыг шалгаруулна. Тэтгэлэгийн хэмжээ тус бүр 750,000 төгрөг.
- Насан туршийн боловсролын онлайн хичээлийн 3 төслийн саналыг сонгон шалгаруулна. Тус бүр 1,500,000 төгрөгийн мөнгөн тэтгэлэг олгоно.

E-Нээлттэй Институт болон шалгарсан төслийн багш нар хамтын ажиллагааны гэрээ байгуулснаар төсөл хэрэгжилтийн эхэнд тэтгэлэг олгогдоно.

Төслийн материал бүрдүүлэлт

Төслийн саналд дараах мэдээллийг оруулсан байх шаардлагатай.

- E-Хичээл хамтран хийх багшийн талаарх товч танилцуулга
- Хичээлийн тухай /1-2 хуудас/
 - Хичээлийн нэр

- Хичээлийн удиртгал, танилцуулах хэсэг
- Хэдэн кредит, аль сургалтын хөтөлбөрийн хичээл болохыг тодруулж бичнэ
- Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө /7 хоногоор, лекц, семинараар гэх мэт/
- Хичээлээ е-хичээл болгох хүсэлт. Үүнд дараах мэдээллийг багтаана /1-2 хуудас/:
 - Таны е-хичээл хэнд, ямар оюутнуудад зориулагдах вэ?
 - Таны е-хичээлийг үзсэнээр оюутан, суралцагчид ямар мэдлэгийг эзэмшиж, ямар үр дүнд хүрэх вэ?
 - Е-хичээлийг хөгжүүлж, онлайнаар хичээл заах нь таны хувьд ямар үр дүнтэй болох, та энэ хамтын ажиллагаанаас ямар давуу тал болон эргэлзээтэй талуудыг харж байна вэ? Е-Нээлттэй Институтын зүгээс ямар нөөц бололцоо, үр дүн хүлээж байна вэ?
- Төслийн саналыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө. Төслийг хамтран хэрэгжүүлж дуусгах хугацааг үндэслэн багш өөрийн бололцоотой ажлын цагийн төлөвлөгөө, е-хичээлийг хамтран хийж дуусгах хугацааг нарийн гаргаж ирүүлэх.
- 2-5 минутын хичээлийн танилцуулга видео бичлэг. Энэхүү бичлэг нь оюутан суралцагчдад яагаад таны хичээлийг үзэх шаардлагатай, ямар мэдлэгийг эзэмшиж, суралцах талаар хандаж хэлсэн байна. Өндөр чанартай бичлэг байх шаардлагагүй. Видео бичлэгийн техникийн туслалцааг munhbat@must.edu.mn емейл хаяг болон 99153207 /Мөнхбат/ утсаар хандаж авч болно.
- Багшийн талаас е-хичээл болон онлайн хичээлийг хөгжүүлэхэд шаардлагатай техникийн болон програм хангамжийн хүсэлтээ тусгайлан гаргаж болно.
- Тэнхимийн эрхлэгчийн е-хичээл болгохыг хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт /Академик е-хичээл, шинэчлэн сайжруулах е-хичээлд хамаатай/.
- Сургуулийн захирлын е-хичээл болгохыг хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт /Зөвхөн академик е-хичээл болон е-хичээлийг шинэчлэн сайжруулах төслийн саналд хамаатай/
-

Хугацаа:

Төслийн санал шалгаруулалтын хугацаа: 2015.11.30-2015.12.09

Сонгон шалгаруулалтын хариу гарах өдөр: 2015.12.17

Хамтын ажиллагааны гэрээ хийх хугацаа: 2015.12.18-2015.15.23

**“Нийтийн, насан туршийн, нээлттэй боловсрол”/МООС/ төсөл шалгаруулах
хөтөлбөр 2015**

Төслийг хэрэгжүүлэх хугацаа: 2016.01-2016.05сар / Е-хичээлийн цар хүрээнээс
хамаарна/

Төслийн саналын емайлээр dulmaa@must.edu.mn хаягаар болон биеэр Е-Нээлттэй
Институтын 404 тоотод авчирч өгнө үү. Утас: 324085 / дотуур 1014/, 99138422

Е-НЭЭЛТТЭЙ ИНСТИТУТ, ШУТИС